

МОНГОЛ-ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА БА ТЭДГЭЭРИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ

*А.Даваасүрэн**

Нэг. ОХУ-ын эдийн засгийн байдал

Орос улс 862 жилийн түүхтэй улс бөгөөд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Улс задран унасны дараа 1991 оны 12 дугаар сарын 26-ний өдрөөс эхлэн Оросын Холбооны улс гэж нэрлэгдэх болсон. Ерөнхийлөгчийн засаглалтай Холбооны Бүгд Найрамдах улс юм. ОХУ-ын нийслэл Москва хот, албан ёсны хил орос хил, 141,9 сая хүн амтай, газар нутаг нь Зүүн Европ болон Хойд Азийг дамнан 17075400 км² талбайд оршин байрладаг. Дэлхийн 18 улс оронтой далай болон хуурай газраар хиллэдэг, дэлхийн хуурай газрын 1/9-ийг эзэлдэг.

ОХУ нь нефть болон байгалийн хий, эрдэс баялагын нөөцөөр дэлхийд хамгийн баян оронд тооцогддог. Нийт газар нутгийн 45 хувь нь ойгоор бүрхэгдэж дэлхий дээр ойн нөөцөөр нэгдүгээр байрт орж, ойн нөөцийн 5/1 нь энэ улсад байрладаг, дэлхийн хамгийн олон тооны нуур, цөөрөмтэй бөгөөд дэлхийн цэвэр усны нөөцийн 4/1 энэ улсад байна.

ОХУ нь эдийн засгийн багтаамж, хүчин чадлаараа дэлхийд 7-р байрт, байгалийн хийн экспортын хэмжээгээр 1-р байрт, нефт, нефтийн бүтээгдэхүүний экспортын хэмжээгээр 4-р байрт ордог улс юм. 2008 оны дунд гэхэд ОХУ Их-8 орнуудын дунд эдийн засгийн 8,5 хувийн өсөлтөөр тэргүүн байрт орж байсан. Хэдийгээр дэлхий нийт санхүү эдийн засгийн хямралтай байсан ч ОХУ-ын 2009 онд эдийн засгийн өсөлтийг 6,7 хувьд хүргэнэ гэж тооцож байсан боловч 2009 онд эдийн засгийн өсөлт 2,9 хувь болсон байна.

ОХУ-ын макроэдийн засгийн үзүүлэлт

	1999	2000	2002	2004	2006	2007	2008	2009
1 ДНБ-ний өсөлт (хувиар)	6,4	10,0	4,9	7,2	7,7	8,1	5,6	2,9
2 Инфляц	36,5	20,2	15,1	11,7	9,0	11,9	13,3	8,8
3 Рублийн дундаж ханш	24,6	28,1	31,4	28,8	27,2	25,6	24,8	31,7
4 Галдад өр (тэрбум доллар)	178,2	160,0	152,3	213,5	313,2	471,0	479,9	469,7
5 Алт валютын нөөц (тэрбум доллар)	12,5	28,0	47,8	124,5	303,7	478,8	427,1	439,0
6 Амьжиргааны баталгаажих төвшингөөс доошхи нэн ядуу хүн амын тоо (хувиар)	28,3	29,0	24,6	17,6	17,7	15,2	13,3	13,2
7 Ажилгүйдлийн түвшин (хувиар)	13,0	10,5	8,0	8,2	7,2	6,1	6,4	8,4

* А.Даваасүрэн - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), профессор

2007 онд ОХУ-д 1 хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 13,3 мянган доллар байсан бол дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас үүссэн гадаад зах зээл дээрх тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан 2008 онд 11,8 мянган доллар, 2009 онд 8,8 мянган доллар болон буурсан байна.



ОХУ-ын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн



ОХУ нь түүхий нефть болон нефть бүтээгдэхүүн, байгалийн хийн дэлхийн хамгийн том нийлүүлэгчдийн нэг гарцаагүй мөн бөгөөд тус улсын экспортын бүтцэд эдгээр эрдэс түүхий эд зонхилж, түүнээс орох орлогоор улсын төсвийн орлогынхоо ихэнхийг бүрдүүлдэг улс юм. Энэ орны эдийн засаг нь бүхэлдээ эдгээр барааны дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамаардаг онцлогтой юм. Тухайлбал 2008 онд эрдэс бүтээгдэхүүний (түүхий нефть, нефтийн бүтээгдэхүүн, автобензин, дизель түлш, мазут, байгалийн хий,) экспортын хэмжээ нь нийт экспортын 78 хувийг эзлэж байсан бол 2009 онд түүхий нефть болон нефть бүтээгдэхүүний экспорт 77 хувь хүртэл өссөн байхад харин байгалийн хийн экспортын хэмжээ 8 хувь болтол буурсан байна. Хэдийгээр дэлхийн зах зээл дээр түүхий нефть болон нефть

бүтээгдэхүүний үнэ огцом унасан боловч эрэлт өндөр хэвээрээ байсан учир экспортлосон эрдэс бүтээгдэхүүний тоо хэмжээ өмнөх жилүүдээс буурахгүй нийлүүлэлт болон экспортын орлого хэвийн байсан гэж тайлбарлаж болно. Харин байгалийн хийн хувьд 2008-2009 оны зааг дээр ОХУ, Украин улсуудын хооронд байгалийн хийн нийлүүлэлтийн төлбөр тооцооноос үүссэн маргаанаас болж тус улсын хамгийн том хэрэглэгч болох Европын холбооны зах зээл рүү нийлүүлэх байгалийн хийн экспорт тасалдахад хүрсэн.

Хэдийгээр өнгөрсөн онд нефть болон нефть бүтээгдэхүүний экспортоос орох орлогын хэмжээ буураагүй боловч ОХУ-ын дотоод зах зээл дээрхи инфляц үнийн өсөлтөөс болж эдийн засаг хямралд өртсөн.

2004 оноос эхэлсэн дэлхийн зах зээл дээр түүхий нефть болон нефть бүтээгдэхүүн, байгалийн хийн үнэ тогтмол өсөх болсоноор ОХУ-ын экспортын орлого огцом нэмэгдэж тус улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох рублийн гадаад валюттай харилцах ханш тасралтгүй чангарах болсон. Үүнтэй холбогдон гадаадаас оруулах өргөн хэрэглээний барааны импортын хэмжээ нэмэгдэж дотоодын үйлдвэрийн бараануудтай өнгө үзэмж чанарын хувьд өрсөлдөх чадваргүй болсоноор энэ төрлийн экспортын барааны үйлдвэрлэл багасах болсон.

Энэ үед тус улсын төр, засгийн газраас нефть болон байгалийн хийнээс орсон орлогоор эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх зорилгоор үндэсний аж үйлдвэрт сэргээн босгоход ихээхэн хөрөнгө оруулалт хийх замаар техник технологийн шинэчлэл хийх, дэлхийд өрсөлдөхүйц цоо шинэ салбарыг бий болгоход бага анхаарал тавьж байсан гэж үздэг. Тэд сонгуулийн үеэр авсан амлалтаа биелүүлэхийн тулд ард иргэдийн орлогын ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэх, өдөр тутмын хэрэглээнд хөрөнгийн ихэнхийг зарцуулж байсан. Өөрөөр хэлбэл экспортын орлогыг нийгмийн халамж үйлчилгээ болон тэтгэвэр, тэтгэмж, цалин хөдөлмөрийн хөлсийг үндэслэлгүй нэмэгдүүлэхэд шууд зарцуулж популист арга хэмжээг авсны үр дүнд энэ нь эргээд улс орны эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг үзэгдлийг дагуулж өргөн хэрэглээний барааны үнийн индексийг (инфляц) удирдлагагүйгээр хурдацтай өсгөхөд хүргэсэн.

Тухайлбал 2008 оны 7-р сарын 08-ний өдөр дэлхийн зах зээл дээр 1 баррель түүхий нефтийн 147 ам.долларт хүрч байхад ОХУ-ын эдийн засаг халалтын хамгийн дээд оргилдоо хүрч байсан. Энэ байдлаас гарахын тулд тухайн үед ОХУ-ын Төв банкны тэргүүн рублийн ханшийг бууруулах (девальваци) арга хэмжээ авахаар төлөвлөж байгаагаа удаа дараа мэдэгдэж байсан боловч шийдвэртэй арга хэмжээг авч хэрэгжүүлж чадаагүй.

ОХУ-ын гадаад худалдаа нь тогтмол ашигтай гардаг энэ үзүүлэлт нь улам нэмэгдэх хандлагатай байна. Энэ ашигтай байдал нь ОХУ-ын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх нэг томоохон хүчин зүйл болсоор байна.

Гадаад худалдаа

		1999	2000	2002	2004	2006	2007	2008	2009
1	Экспорт (тэрбум доллар)	75,6	105,0	107,3	183,2	303,6	354,4	471,6	303,3
2	Импорт (тэрбум доллар)	39,5	44,9	61,0	97,4	164,3	223,5	291,9	192,7
3	Гадаад худалдааны баланс	36,1	60,1	46,3	85,8	139,3	130,9	179,7	110,6

ОХУ-ын худалдааны гол түнш улсууд

Д/д	Экспортын гол түншүүд	Нийт экспортод эзлэх хувь	Д/д	Импортын гол түншүүд	Нийт импортод эзлэх хувь
1	Голланд	12,0	1	Хятад	13,6
2	Итали	8,3	2	Герман	12,7
3	Герман	6,2	3	АНУ	5,5
4	Белорус	5,5	4	Украин	5,4
5	Турк	5,4	5	Франц	5,0
6	Украин	4,6	6	Итали	4,7
7	Польш	4,1	7	Япон	4,3
8			8	Белорус	4,0

ОХУ-ын түүхий нефть болон нефтийн бүтээгдэхүүн, байгалийн хийний ихэнхи хувийг Европын зах зээл рүү экспортлож оронд нь БНХАУ, Герман, АНУ-аас машин техник, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, гэр ахуйн болон өргөн хэрэглээний бараа болон хүнсний бүтээгдэхүүнийг импортоор авдаг байна.

В.Путин 2003 онд ОХУ-ын Ерөнхийлөгч байхдаа 10 жилийн хугацаанд ДНБ-ний үйлдвэрлэлийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх зорилт тавьж ОХУ 2020 он гэхэд орос хүний дундаж цалинг 30 мянган долларт хүргэх, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх инновацийн бүтээгдэхүүний хэмжээ 6 хувь байгааг 2020 он гэхэд 25 хувиар өсгөнө гэсэн хэт амбицласан зорилтыг нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлалдаа тусгасан. Мөн оросын жирийн иргэний бодит орлогыг 2 дахин өсгөх ёстой ба хүн амын тоо буурч байгааг зогсоож, төрөлтийг нэмэгдүүлж, хүний дундаж наслалтыг уртасгаж 75 жилд хүргэх зорилт тавьсан. Энэхүү үзэл баримтлалд Орос улсын эдийн засаг нефть, байгалийн хийнээс хамааралтай байдлаас гаргаж инновацийн салбар руу шилжих зорилтыг хэрэгжүүлж өндөр технологийн салбарын ДНБ-д эзлэх хувийн жинг 17-20 хувьд хүргэнэ. Түүнчлэн ОХУ-ын 2007 онд дэлхийн эдийн засагт эзлэж байсан 3,2 хувийн жинг 2015 он гэхэд 3,8 хувь, улмаар 2020 онд 4,3 хувьд хүргэнэ гэсэн зорилт тавьж байсан.

Гэвч 2008 оны 10 дугаар сарын дунд үеэс дэлхийн санхүүгийн хямралын анхны шинж тэмдэгүүд илэрч дэлхийн томоохон санхүүгийн зах зээлүүд дээр гол индексүүд унах болж улмаар АНУ-ын хамгийн

том банкуудын нэг “Лейман братс” дампууралаа анх удаа зарлах болсон үеэс дэлхийн санхүүгийн хямрал шаталсан хэлбэрээр даамжирч 2009 оны 4 сард хамгийн хурц мөчлөгтөө хүрч улмаар эдийн засгийн хямралын шинжтэй болсон. Энэхүү хямралтай холбоотой дэлхийн хэмжээнд зээл, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны төлбөр тооцоог хийхэд ноцтой хүндрэл бэрхшээлүүд үүсэж, улмаар дэлхийн зарим томоохон орнуудын аж үйлдвэрлэл зогсонги байдлаас болж дэлхийн зах зээл дээрх түүхий нефтийн эрэлт огцом буурч 2008 оны 8-12 сарын хооронд ердөө 4 сарын дотор 1 баррель нефтийн үнэ 174-40 ам.доллар хүртэл маш хурдацтай унасан.

ДНБ-тэй харьцуулсан улсын төсвийн үзүүлэлт (хувиар)

Д/д		1999	2000	2002	2004	2006	2007	2008
1	Улсын төсвийн орлого	25,2	28,7	32,5	31,9	39,5	40,4	38,4
2	Улсын татварын орлого	20,9	23,4	25,8	29,0	20,1	20,9	19,1
	Улсын төсвийн зарлага	26,1	26,8	31,6	27,4	31,1	34,4	33,6
3	Улсын төсвийн тэнцэл	-0,9	1,9	-0,9	4,5	8,4	6,0	4,8

Манай оронтой харьцуулахад ОХУ холбооны төсвөө 3 жилээр төлөвлөдөг, 2002 оноос хойш холбооны төсвийн нийт тэнцэл тогтмол ашигтай гарсаар ирсэн онцлогтой боловч 2009 онд Холбооны төсөв анх удаа алдагдалтай гарч ДНБ-ний 8 хувь байх урьдчилсан тооцоо гаргасан байна. Энэ нь ОХУ-ын экспортын барааны гол бүтээгдэхүүн болох нефть, байгалийн хийн дэлхийн зах зээл дээрх үнийн огцом уналтаас болж улсын төсөвт орох орлогын хэмжээ тогтмол буурч байгаатай холбоотой юм гэж үзэж болно.

ОХУ нефть байгалийн хийнээс олох экспортын орлого 6,23 триллион рублээр төлөвлөсөн боловч 2009 оны 8 сарын байдлаар нефть байгалийн хийн экспортын орлогоос төсөвт 1,63 триллион рубль төвлөрч 4,6 триллион рублийн орлого тасалдаж байна.

2008 оны 8 сард ОХУ-ын гадаад валютын албан нөөцийн хэмжээ 597 тэрбум ам долларт хүрч 1,9 тэрбум ам.долларын валютын нөөцтэй БНХАУ, 795,9 тэрбум долларын нөөцтэй Япон улсын дараа дэлхийд гуравдугаар байрт орж байсан. Харин дэлхийн эдийн засгийн хямралаас болж 2009 оны 12 сар гэхэд ОХУ-ын валютын нөөц 441 тэрбум доллар хүртэл буурч Европын Холбооны улсуудын дараа орж дэлхийд дөрөвдүгээр байр руу ухарсан байна. Хэрэв дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал 2010 он болон цаашид үргэлжилбэл ОХУ олон жилийн хугацаанд нөөцөлсөн валютын нөөцөө дуусгахад хүрч болзошгүй гэж мэргэжилтнүүд эмзэглэж байсан. Гэвч 2010 оны 4 дүгээр сарын 1 гэхэд ОХУ-ын валютын нөөцийн хэмжээ 439,034 млрд

доллаароос 447,004 млрд доллар болж өссөн гэж ОХУ-ын Төв банкны гадаад харилцааны газраас мэдээлж байсан.

Хямралын үед ОХУ-ын Төв банкаас улс орныхоо эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд эдийн засгийн гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөлөлд үнэлэлт дүгнэлт өгч 2009 онд болон 2010-2011 онд төрөөс хэрэгжүүлэх мөнгө зээлийн 3 жилийн бодлогынхоо үндсэн чиглэлийг хэрэгжүүлж байна. Энэхүү бодлогын үндсэн зорилго нь инфляцийг онилох замаар үе шаттайгаар бууруулахад чиглэгдэж байна. Гэвч мөнгө-зээлийн бодлого нь сүүлийн жилүүдэд хадгалагдаж ирсэн удирдлагатай хөвөх ханшны журмыг үргэлжлүүлэх ерөнхий дүр зураг ажиглагдаж байна. Энэ нь инфляцийг багасгахад валютын ханшийг хянах, валютын ажилбарт бивалютын сагсыг хэрэглэх зорилготой мөнгөний бодлого хэрэгжүүлнэ гэсэн үг.

Энэ бодлогын үр дүнд Төв банкнаас инфляцийг 2009 онд 8,8 хувь хүртэл бууруулж чадсан. ОХУ-ын Засгийн газраас санхүү эдийн засгийн хямралаас гарахын тулд банкны системийг дэмжих зорилгоор 40 тэрбум долларын нэмэлт санхүүжилт хийж арилжааны банкуудыг хөрөнгөжүүлж байна.

ОХУ-ын эдийн засаг 2008 оны дараах уналтын үеийн шокноосоо гарсан үгүй талаар эрдэмтэн судлаачдын дунд сүүлийн үед маргаан их гарч байна. ОХУ-ын Засгийн газрын эдийн засгийн чиглэлийн яамдуудын удирдагчдын ихэнхи нь энэ байдалд өөдрөг хариуг өгч байна. Тэд үйлдвэрлэлийн огцом уналт зогсож улмаар тогтворжих хандлага ажиглагдаж, дэлхийн болон ОХУ-ын хөрөнгийн бирж дээр арилжаа идэвхийж, үнэт цаасны ханшны уналт зогсож, рублийн ханш чангарч ажилчдын цалинг тавьж чадахгүй байсан, ажилгүйдлээс үүсэж байсан нийгмийн бухимдал бараг байхгүй болж байгаа нь эдийн засгийг босгох үндэс суурь болж байна гэж үзэж байна. Хэрэв эдийн засагт бүтцийн өөрчлөлтийг хийхгүйгээр, технологийн шинэчлэлийг хийгүйгээр, аж үйлдвэрийн хөгжлийн дэд бүтцийг хөгжүүлэхгүйгээр эдийн засаг эрүүлжих асуудал зүүн дээр байгаатай адил гэж судлаачид үзэж байна. Баррель түүхий нефтийн дэлхийн зах зээлийн үнэ 70 ам.долларын түвшинд (харин 1 баррель нефтийг олборлох өөрийн өртөг нь 10-15 ам.доллар) хүрч байгаа нь ОХУ-ын зарим эрх баригчдад өөдрөг сэтгэгдэл төрүүлж байна гэж шүүмжлэл ч гарч байна.

Хоёр. Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн харилцаа ба тэдгээрийн ашиг сонирхолын зөрчлийн асуудал

Манай хоёр улсын хувьд арилжаа, худалдааны харилцаа нь өнө эрт дээр үеэс эхэлсэн түүхэн баялаг уламжлалтай билээ. Монгол Улс мал аж ахуйн итүүхий эд болох ноос, ноолуур арьс шир, ангийн үсийгээ Орос улсад нийлүүлээд оронд нь хүнсний бараа болон хүний

амьжиргаа хэрэгцээннд шаардлагатай өргөн хэрэглээний барааг авч өөрсдийнхөө хэрэгцээг хангаж ирсжэн уламжлалтай билээ.

Хоёр улсын гадаад худалдаанд доривтой хэмжээний өсөлт одоохондоо ажиглагдахгүй байна. Энэ байдлыг бодитойгоор авч үзвэл ОХУ-ын эрх баригчдын зүгээс хоёр улсын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд ажил арга хэмжээ авахыг хүсэхгүй байна. Үүнийг дараах хүснэгтээс харж болно.

д/д	Үзүүлэлт	1991	1993	1995	1998	2000	2003	2005	2007	2008
1	Худалдааны нийт эргэлт	473,5	365,5	276,9	190,8	251,3	306,3	445,2	803,5	1328,6
2	Монгол Улсын экспорт	238,3	145,2	68,9	40,6	45,1	41,2	27,2	58,5	86,3
3	Монгол Улсын импорт	235,2	220,3	208,0	150,2	206,2	265,1	417,9	745,0	1242,3
4	Худалдааны баланс	3,1	-75,1	-139,1	-109,6	-161,1	-223,9	-390,7	-686,5	-1156,0

Эх үүсвэр: Монгол Улсын ҮСХорооны жил тутмын статистикийн эмхтгэл. (1990-2008)

1990 онд хоёр улсын худалдааны эргэлт 1233,7 сая ам.доллар хүрч байсан нь түүх болон үлдсэн бөгөөд энэ хэмжээ 1991 онд огцом буурч 473,5 сая ам.долларт хүрч улмаар 1998 онд хамгийн доод түвшинд буюу (1990 оны хэмжээнээс 15,4 хүртэл хувиар буурсан) 190,8 сая ам.долларт хүрч цаашид бага зэрэг өсөх хандлагатай байна. Гэвч энэхүү өсөлт манай хоёр орны ард түмний өнөөгийн хүсэл сонирхол, хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүрэхгүй байна. Монгол Улсын ОХУ-тай хийх гадаад худалдааны тэнцлийн хувьд хэтэрхий тэгш бус байдал үүссэнээс манай улс бага ханамж авч байна гэж тайлбарлаж тайлбарлаж болно.

Манай улсын эдгээр бараа, бүтээгдэхүүнийг ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын бүс нутгийн хэрэглэгчид маш их сонирхдог боловч өмнө дурьдсан өндөр тариф, татвар, элдэв төрлийн хориг саад, хязгаарлалтууд манай барааны үнийг өсгөж энэ нь ОХУ-ын зах зээл дээр Хятад улсын нийлэг эдээр хийсэн маш хямд бараа, бүтээгдэхүүнтэй өрсөлдөж чадахгүй болгож манай барааны борлуулалт буурч улмаар зах зээлээс шахагдахад хүргэж байна.

ОХУ-ын хэрэглэгчдэд Монгол Улсын уламжлалт экспортын бараа, бэлэн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрийн үнээр нь нийлүүлэх өргөн боломж байгаа боловч худалдааны нөхцлөөс болж асуудал шийдлээ хүлээсээр нилээд олон жилийн нүүрийг үзэж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улс нийт экспортынхоо 3 орчим хувийг ОХУ-ын зах зээл рүү гаргаж, импортынхоо 36 хувийг авч байна. ОХУ-аас оруулах Монгол Улсын импортын 30-аад хувийг нефтийн бүтээгдэхүүн (автобензин, дизелийн түлш, онгоцны бензин, мазут, байгалийн хий) эзлэж байна. Манай улс импортын нефтийн бүтээгдэхүүнийхээ 99 хувийг буюу 700 гаруй мянган тонныг зөвхөн ОХУ-аас авдаг.

ОХУ нефтийн бүтээгдэхүүн экспортын татвараа 2 сар тутамд хянадаг механизм үйлчилдэг бөгөөд энэ татварын хэмжээ нэмэгдэхэд манай улсын эдийн засаг, инфляцид шууд сөргөөр нөлөөлдөг зүй тогтолтой болоод удаж байна. Манай улсын зүгээс дээрх экспортыг болон импортын гаалийн татвар, төмөр замын тарифыг бууруулах талаар олон удаа тавьдаг боловч ОХУ-ын зүгээс Монгол Улсад дангаар нь ийм төрлийн хөнгөлөлт үзүүлэх боломжгүй гэдэг бөгөөд манай улсын ОХУ, Казакстан, Белоруссын гаалийн холбоонд эсвэл Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлд (ТУХН) элсэх саналыг сөргүүлэн тавьдаг. Манай улсын хувьд Казакстан, Белорус зэрэг улсуудтай шууд хилэлдэггүй тул манай улсыг энэхүү холбоонд элсэхэд эдгээр улсуудын зүгээс дэмжлэг авах магадлал маш бага байгаа учир элсэх боломж одоохондоо хягаарлагдмал байна. Харин ТУХН-д элсэх боломж нилээд нээлтэй бөгөөд юуны өмнө энэхүү нөхөрлөлийн гишүүдтэй хоёр талын хэлэлцээрийг байгуулж дэмжлэг авах шаардлагатай болно.

Түүнчлэн Монгол Улс ОХУ-тай Чөлөөт худалдааны Хэлэлцээр байгуулсанаар худалдаанд оршиж байгаа дээрхи хориг саадуудыг арилгах боломжтой болно.

Хоёр орны ашиг сонирхол ба тэдгээрийн зөрчил

Монголын талаас:

- Экспортын бараанд оногдуулж байгаа тарифын болон тарифын бус хориг саадыг арилгах,
- Экспортын махны тоон хязгаарлалт, мал, эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн дэглэм, журмыг уян хатан болгох,
- Төмөр замын өндөр тарифыг багасгах
- 1949 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Монгол, Оросын хамтарсан “УБТЗ” нийгэмлэгийн тухай гэрээг шинэчлэх замаар Монголын талын оролцоог нэмэгдүүлэх
- Нефтийн экспортын татварыг бууруулах,
- Сибирээс Ази Номхон Далайн бүс нутаг руу татах байгалийн хийн хоолойг МУ-ын нутгаар дамжуулан өнгөрүүлэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх
- “Дамжин өнгөрүүлэх тээврийн тухай” Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хэлэлцээр байгуулах,
- Хил орчмын болон бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, (Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт худалдааны бүс байгуулах)
- Аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах,

ОХУ-ын талаас:

- Монгол Улсад шинээр тавих ашигт малтмалын томоохон орд газруудыг холбосон төмөр замын болон дэд бүтцийн сүлжээг барихад оролцох,

- Таван толгойн болон бусад ашигт малтмалын томоохон орд газрыг ашиглахад оролцох,
- “Дорнод уран” компанийг байгуулж ураны орд газрыг хамтран ашиглах,
- 1949 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн Монгол, Оросын хамтарсан “УБТЗ” нийгэмлэгийн тухай гэрээг шинэчлэх замаар Оросын тал өөрийн хувь оролцоог хэвээр хадгалах сонирхол,
- Хил орчмын худалдааг өргөжүүлэх,

Иймд хоёр орны худалдаанд оршиж байгаа дээрх хориг саадуудыг арилгаж цаашдын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэхэд шинэ нөхцөл байдалд ОХУ, манай улсын ашиг сонирхолуудыг гэрээ хэлэлцээрийн шугамаар асуудлыг цогцоор нь авч үзэн ялангуяа Монголын талаас тавьж буй асуудлыг ОХУ-ын талаас тавьж байгаа асуудалтай сэргүүлэн тавих замаар харилцан тохиролцож хөгжүүлэх хоёр улсын ашиг сонирхлын адил тэгш байдлыг хангах замаар худалдаа эдийн засгийн харилцааг урьд байсан түвшинд хүртэл сэргээх хэрэгцээ шаардлага байгааг анхаарах хэрэгтэй байна.